



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/588

Номгон


Цагдаагийн газрын 100 жилийн ойн баярыг
тохиолдуулан хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Цагдаагийн газрын 100 жилийн ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагдаагийн газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор албан хэрэгцээнд зориулан иж бүрэн компьютерийг худалдан авахад шаардагдах 2,695,000 (Хоёр сая зургаан зуун ерэн таван мянган) төгрөг зарцуулсугай.

2.Зардлын 2,695,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210377